

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	2
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал...5	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	5
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	6
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	6
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан	8
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Я.БОЛДБААТАР ТАНАА

2019.02.25 № 06/294
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8.9.1 дугаар зүйлд заасны дагуу “Туул голын сав газрын захиргаа”-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Туул голын сав газрын захиргаа”-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Туул голын сав газрын захиргаа”-ны 2018 оны төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл, тодруулга тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Я. Болдбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 11-нээс 2019 оны 2 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, УАГ-ын захиалгаар Акпар Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Туул голын сав газрын захиргаа 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 02/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Туул голын сав газрын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Туул голын сав газрын захиргаа нь Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага юм. Төрөөс усны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх стратегийн зорилтын хүрээнд “Ус” үндэсний хөтөлбөр болон “Хатан туул” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Усны тухай болон Ус бохирдуулсан төлбөрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх стратеги зорилтуудын хүрээнд тодорхой ажлуудыг хийх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 203 тоот тогтоолоор Туул голын сав газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Туул голын сав газарт усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх

Туул голын сав газрын захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Туул голын сав газрын захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Усны тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль

- Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хууль
- Тусгай хамгаалалтын газар нутгийн орчны бүсийн тухай хууль
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль

Дээрх хууль, журмуудад тайлант хугацаанд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Туул голын сав газрын захиргааны даргын 2018 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн А/59 тоот тушаалаар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан мөрдөж эхэлсэн байна.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Туул голын сав газрын захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Туул голын сав газрын захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Туул голын сав газрын захиргаа нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас гүйцэтгэдэг байна.

2018 оны 12 дугаар сард тус хорооноос харъяа байгууллагуудын 2017, 2018 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Туул голын сав газрын захиргаанд 13 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Туул голын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Туул голын сав газрын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо

олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 38 нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн 2 /хоёр/ хувиар сонгов.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн дүнг сонгосон нь тэвчиж болох хамгийн бага дүнг сонгосонтой холбоотой юм.

Туул голын сав газрын захиргааны 2018 оны нийт хөрөнгө 228,948.00 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 4,578.96 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь нийт хөрөнгийн дүн харьцангуй бага байсантай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 16 чиглэлээр аудитын 38 горим сорил гүйцэтгэхэд алдаа, зөрчил илрээгүй.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Залруулагдаагүй алдаа гараагүй.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус захиргаанд анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхөж, үлдэгдэл өртөггүй болсон ашиглагдах хугацаа нь дуусч, цаашид ашиглах боломжгүй болсон 27 нэр төрлийн 47 ширхэг хөрөнгө үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй явдаг байна. Эдгээр хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцэж, зохих журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулан, актлах шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Барилга байгууламжийн дансанд мониторингийн цооногууд бүртгэлтэй байна. Цооногуудыг яаж үнэлэх талаар Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх аргачлалд тусгагдаагүй, мөн ТӨБЗГ-т Сангийн яамны 2018 оны 12 дугаар сарын 17-ны 7/7740 тоот албан бичгээр ирүүлсэн “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлалын нэмэлт зөвлөмж”-д дээрх (САГ-2019/371/СТА-ТШЗ)

цооногуудыг дахин үнэлэх талаар аргачлал байхгүй тул үнэлгээ хийгдээгүй гэсэн тайлбарыг тус газраас өгсөн.

Дээрх ашиглалтгүй болсон хөрөнгийг зохих журмын дагуу актлуулсан эсэхийг дараагийн аудитор хянах нь зүйтэй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Туул голын сав газрын захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 325,125.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 219,240.4 мянган төгрөг буюу 98.19 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулснаас шалтгаалжээ. Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө өгөөгүй байгаа ч тус байгууллага нь урсгал зардлын төсвийг 5.9 сая, нэмэгдэл төсвийг 4.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж мөн үйл ажиллагаанаас 27.6 сая төгрөгийн орлого оруулж, улсын төсөвт 37.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Туул голын сав газрын захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу <https://shilendans.gov.mn/> сайдад Туул голын сав газрын захиргааны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 2018 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг сар, улирлаар нь тавьсан байна. Мөн тус байгууллагын санхүүгийн тайлан болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах боломжийг бүрдүүлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар “Туул голын сав газрын захиргаа”-ны 2017 оны санхүүгийн тайланд “Атланта баланс-Аудит” компани аудит хийсэн ба зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Туул голын сав газрын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,270,374.49</u>	<u>30,954,562.49</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	36,270,374.49	30,954,562.49
354	Хангамжийн материал	36,270,374.49	30,954,562.49
35410	Бичиг хэргийн материал	1,874,550.00	2,065,450.00
35420	Аж ахуйн материал	31,573,824.49	26,214,112.49
35430	Сэлбэг хэрэгсэл	1,734,000.00	1,959,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,088,000.00	716,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>236,695,517.80</u>	<u>197,993,441.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	236,695,517.80	197,993,441.66
392	Биет хөрөнгө	236,485,976.58	197,867,716.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	155,264,075.19	155,264,075.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	29,934,124.59	37,697,328.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,276,144.37	86,276,144.37
39204	Хуримтлагдсан элэгдэл	85,555,004.69	85,853,446.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	297,545,460.30	299,835,260.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	201,706,814.62	230,739,493.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,301,156.44	37,301,156.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	22,974,232.82	26,787,968.30
39217	Ном	269,317.00	269,317.00
393	Биет бус хөрөнгө	209,541.22	125,724.70
39301	Програм хангамж	1,105,266.00	1,105,266.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	895,724.78	979,541.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>272,965,892.29</u>	<u>228,948,004.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>272,965,892.29</u>	<u>228,948,004.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	272,965,892.29	228,948,004.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	346,824.00	346,824.00
51101	Өмч: - төрийн		
51102	- хувийн		
512	Хуримтлагдсан үр дүн	272,619,068.29	228,601,180.15
51210	Өмнөх үеийн үр дүн	314,519,953.03	272,619,068.29
51220	Тайлант үеийн үр дүн	-41,900,884.74	-44,017,888.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>272,965,892.29</u>	<u>228,948,004.15</u>

3.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	356,898,200.00	400,743,511.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,317,511.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,317,511.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,898,200.00	396,426,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,457,400.00	325,125,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,457,400.00	325,125,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,440,800.00	71,301,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,900,000.00	25,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,470,800.00	16,186,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,070,000.00	27,565,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	398,799,084.74	444,761,399.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,799,084.74	444,761,399.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,232,350.66	390,772,643.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,945,586.45	219,732,062.00
210101	Үндсэн цалин	163,548,186.45	178,644,937.00
210102	Нэмэгдэл	34,788,300.00	25,232,583.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,609,100.00	15,854,542.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,143,470.65	26,896,044.79
210201	Тэтгэврийн даатгал	15,451,082.87	16,226,288.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,187,936.77	2,216,774.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,748,718.16	2,044,372.79
210204	Ажилгүйдлийн даатгал	432,338.43	1,073,099.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,323,394.42	5,335,511.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,892,277.91	17,902,228.07
210301	Гэрэл, цахилгаан	10,511,589.00	9,439,351.37
210302	Түлш, халаалт	8,380,688.91	8,462,876.70
2104	Хангамж, бараа материалын зардал	27,621,588.91	55,448,178.50
210401	Бичиг хэрэг	2,423,942.00	4,765,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,421,000.00	11,763,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,477,990.91	3,578,314.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,298,656.00	35,340,664.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,507,850.00	4,123,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	68,000.00

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	46,000.00	-
210604	Урсгал засвар	4,461,850.00	4,055,800.00
2107	Томилолт, зочны зардал	11,587,000.00	18,867,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	11,587,000.00	18,867,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,465,790.00	4,621,530.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,843,760.00	2,370,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	985,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	204,930.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	159,100.00	115,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	124,500.00	298,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,068,786.74	43,181,800.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,611,600.00	2,189,924.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,457,186.74	40,991,876.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,566,734.08	53,988,756.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,478,366.00	16,212,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,212,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,478,366.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,088,368.08	37,776,756.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,088,368.08	37,776,756.14
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-41,900,884.74	-44,017,888.14
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-41,900,884.74	-44,017,888.14

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	356,898,200.00	400,743,511.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,317,511.50
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,317,511.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,317,511.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,317,511.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,898,200.00	396,426,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,457,400.00	325,125,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,457,400.00	325,125,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,440,800.00	71,301,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,900,000.00	25,850,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,470,800.00	16,186,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,070,000.00	27,565,000.00
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	353,179,200.00	398,453,711.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,179,200.00	398,453,711.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,612,465.92	344,464,955.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,796,223.24	220,027,417.00
210101	Үндсэн цалин	163,398,823.24	165,697,875.00
210102	Нэмэгдэл	34,788,300.00	32,689,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,609,100.00	21,640,542.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,292,833.86	26,600,689.79
210201	Тэтгэврийн даатгал	15,459,077.18	17,482,584.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,766,749.96	2,204,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,208,440.81	1,750,924.79
210204	Ажилгүйдлийн даатгал	441,686.74	428,185.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,416,879.17	4,734,996.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,892,277.91	17,902,228.07
210301	Гэрэл, цахилгаан	10,511,589.00	9,439,351.37
210302	Түлш, халаалт	8,380,688.91	8,462,876.70
2104	Хангамж, бараа материалын зардал	35,343,021.02	47,534,970.50
210401	Бичиг хэрэг	3,514,200.00	5,287,120.00

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	10,220,000.00	10,881,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,376,221.02	4,014,994.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,232,600.00	27,350,956.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,037,650.00	4,771,196.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	873,800.00	655,396.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	46,000.00	-
210604	Урсгал засвар	4,117,850.00	4,115,800.00
2107	Томилолт, зочны зардал	11,587,000.00	19,377,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	11,587,000.00	19,377,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,079,559.89	4,561,530.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,235,760.00	2,310,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	985,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	204,930.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	159,100.00	115,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,269.89	298,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,583,900.00	3,689,924.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,583,900.00	3,689,924.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,566,734.08	53,988,756.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,478,366.00	16,212,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,212,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,478,366.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,088,368.08	37,776,756.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,088,368.08	37,776,756.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,719,000.00</u>	<u>2,289,800.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,719,000.00	2,289,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,719,000.00	2,289,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,719,000.00	2,289,800.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	3,719,000.00	2,289,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3,719,000.00</u>	<u>-2,289,800.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.4 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	314,519,953.03	314,866,777.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	314,519,953.03	314,866,777.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
C07	Тайлант үеийн үр дүн		-41,900,884.74	-41,900,884.74
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	272,619,068.29	272,965,892.29
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	272,619,068.29	272,965,892.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	272,619,068.29	272,965,892.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
D08	Тайлант үеийн үр дүн		-44,017,888.14	-44,017,888.14
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	228,601,180.15	228,948,004.15

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,125,000.00	319,240,435.36	5,884,564.64	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,125,000.00	319,240,435.36	5,884,564.64	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,913,000.00	303,028,435.36	5,884,564.64	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,578,000.00	220,027,417.00	2,550,583.00	99%
210101	Үндсэн цалин	165,739,400.00	165,697,875.00	41,525.00	100%
210102	Нэмэгдэл	33,729,500.00	32,689,000.00	1,040,500.00	97%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,109,100.00	21,640,542.00	1,468,558.00	94%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,709,300.00	26,600,689.79	108,610.21	100%
210201	Тэтгэврийн даатгал	17,806,300.00	17,482,584.00	323,716.00	98%
210202	Тэтгэмжийн даатгал	2,225,800.00	2,204,000.00	21,800.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,780,600.00	1,750,924.79	29,675.21	98%
210204	Ажилгүйдлийн даатгал	445,100.00	428,185.00	16,915.00	96%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,451,500.00	4,734,996.00	-283,496.00	106%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,365,700.00	17,902,228.07	463,471.93	97%
210301	Гэрэл, цахилгаан	9,710,500.00	9,439,351.37	271,148.63	97%
210302	Түлш, халаалт	8,655,200.00	8,462,876.70	192,323.30	98%
2104	Хангамж, бараа материалын зардал	15,603,300.00	15,370,650.50	232,649.50	99%
210401	Бичиг хэрэг	3,136,300.00	3,089,120.00	47,180.00	98%
210402	Тээвэр, шатахуун	5,833,000.00	5,774,900.00	58,100.00	99%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,077,200.00	4,014,994.50	62,205.50	98%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,556,800.00	2,491,636.00	65,164.00	97%
2105	Нормативт зардал	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,712,000.00	7,060,996.00	1,651,004.00	81%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,593,600.00	2,945,196.00	1,648,404.00	64%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			-	
210604	Урсгал засвар	4,118,400.00	4,115,800.00	2,600.00	100%
2107	Томилолт, зочны зардал	9,371,200.00	9,315,000.00	56,200.00	99%
210702	Дотоод албан томилолт	9,371,200.00	9,315,000.00	56,200.00	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,989,600.00	4,561,530.00	428,070.00	91%

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,316,600.00	2,310,000.00	6,600.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	495,000.00	204,930.00	290,070.00	41%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00	-	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	115,100.00	82,900.00	58%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,500.00	298,000.00	48,500.00	86%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,583,900.00	2,189,924.00	393,976.00	85%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,583,900.00	2,189,924.00	393,976.00	85%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,212,000.00	16,212,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,212,000.00	16,212,000.00	-	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,212,000.00	16,212,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	325,125,000.00	291,600,756.14	33,524,243.86	90%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	325,125,000.00	291,600,756.14	33,524,243.86	90%
131001	Улсын төсвөөс санхүүжих	325,125,000.00	291,600,756.14	33,524,243.86	90%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
610001	Төсвийн байгууллага			-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-	-	
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-	-	
630002	Хувийн ЕБС				
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	-	-	-	
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага				
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага				
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	-	-	-	
632001	Төрийн өмчит МСҮТ				

Туул голын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо				
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо				
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23	-	100%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19	19	-	100%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	-	100%

